



НИЙСЛЭЛИЙН ЦАГДААГИЙН  
УДИРДАХ ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,  
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Ж.Самбууний гудамж, Засгийн газрын XI байр,  
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,  
И-мэйл: contact@afccp.gov.mn, Вэбсайт: www.afccp.gov.mn

2020.02.14 № 1/182  
танай -ны № -т

Тендерийн баримт бичгийг  
хянасан тухай

Танай газраас 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр зарласан “Даатгалын үйлчилгээ үзүүлэх тухай” НЦГ/202001001 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт холбогдох гомдлыг “Мөнх даатгал” ХХК-иас тус газарт ирүүлсний дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд хянан үзлээ.

Захиалагч тендерийн баримт бичгийн ТШӨХ-ийн (12.1) 5-д “Санхүүгийн зохицуулах хорооноос салбарын мэдээллийн буюу нийслэл, төв, орон нутагт санхүүгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй салбарын тоо аймаг бүрд 1-ээс доошгүй байх тодорхойлолт болон салбарт ажиллаж байгаа ажилчид, төлөөлөгч хүмүүсийн НДШ төлсөн тухай НД-ын баталгаажсан тайлангийн хамт ирүүлнэ.” гэж заасан байна.

2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн үнэлгээний хорооны тэмдэглэлд тус тендерт Нийслэлийн цагдаагийн удирдах газар, харьяа нэгж, дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдийн нийт 3031 алба хаагчийн гэнэтийн ослын даатгал, 285 ширхэг тээврийн хэрэгслийн даатгал, 10 барилга байгууламж буюу үндсэн хөрөнгө даатгахаар дурдсан.

Ердийн даатгалын 15 компани байгаагаас аймаг бүрд 1-ээс доошгүй салбартай даатгалын 6 компани үйл ажиллагаа явуулж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа албан хаагч, тээврийн хэрэгсэл, Улаанбаатарт байрлах барилга байгууламжийг даатгахад заавал 21 аймагт салбартай байхыг шаардсан нь тус тендерт оролцох сонирхол бүхий аж ахуй эрхлэгчийн өрсөлдөх боломжийг хязгаарлаж, зарим аж ахуй эрхлэгчид давуу байдал бий болгож, тендерт оролцогчийн өрсөлдөөнийг хязгаарласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэж заасныг зөрчиж байна.

0000687